



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 01/92

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 45 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,910,839.81 /хоёр сая есөн зуун арван мянга найман зуун гучин есөн төгрөг наян нэгэн мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 45 дугаар цэцэрлэг /П.Сайнбилэг/-т зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 7 нэр төрлийн 789,657.11 /долоон зуун наян есөн мянга зургаан зуун тавин долоон төгрөг арван нэгэн мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 11 нэр төрлийн 2,121,182.70 /хоёр сая нэг зуун хорин нэгэн мянга нэг зуун наян хоёр төгрөг далан мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 45 дугаар цэцэрлэг /П.Сайнбилэг/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115759001601

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 12 дугаар
 сарын 12 өдрийн 0/12 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 45 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХК-ын хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж										
1	Тоглуулагч /DVD Next	6	ш	1	49,900.00	49,900.00	49,900.00	-	Уншигч толгой болон удирдлагын хавтан шатсан	татах
2	Принтер	12	ш	1	202,563.90	202,563.90	202,563.90	-	Удирдлагын хавтан шатсан	татах
3	Хөлдөөгч	16	ш	1	305,721.00	305,721.00	305,721.00	-	Хөргөлтийн шингэний хоолой цоорсон, дотор хана цоорхой	татах
4	Аяга, таваг ариутгагч	10	ш	1	120,000.00	120,000.00	120,000.00	-	Тэжээлийн блок гэмтэлтэй	устгах
5	Принтер	15	ш	1	152,000.00	152,000.00	152,000.00	-	Удирдлагын хавтан гэмтэлтэй, сэлбэг олдохгүй	татах
6	Принтер	14	ш	1	586,800.00	586,800.00	586,800.00	-	Шарах бул гэмтэлтэй, сэлбэг олдоцгүй	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн				6		1,416,984.90	1,416,984.90	-		
Тавилга, эд хогшил										

7	Ширээ	14	ш	8	37,225.00	297,800.00	297,800.00	-	Удаан жил ашиглагдсан тул ашиглалтаас хасах.	татах
8	Гал тогооны шүүгээ	6	ш	1	180,000.00	180,000.00	180,000.00	-	ДСП хавтан тул амархан эвдрэл, гэмтэл авдаг. Хүн гэмтээх магадлалтай	татах
9	Дугуй булантай тавиур	16	ш	1	162,810.00	162,810.00	162,810.00	-	Элэгдэл дууссан, булан эвдэрсэн, тогтохоо байсан.	татах
10	1 талтай самбар	14	ш	1	126,565.00	126,565.00	126,565.00	-	Олон жил хэрэглэсэн учир үзэмж муутай.	устгах
11	Тавиур	11	ш	1	75,000.00	75,000.00	75,000.00	-	Удаан жил ашиглагдсан тул ашиглалтаас хасах.	устгах
12	Тоглоомын тавиур 8 тасалгаатай	9	ш	1	61,417.00	61,417.00	61,417.00	-		татах
13	Сургалтын ширээ 4 тасалгаатай	9	ш	1	76,383.30	76,383.30	76,383.30	-		татах
14	Бүтээлийн самбар	11	ш	2	75,000.00	150,000.00	150,000.00	-		устгах
15	Зурагтын тавиур	14	ш	1	134,008.51	134,008.51	134,008.51	-	Хананд тогтоодог хэсэг хугарсан	устгах
16	Пийшин яндан	12	ш	1	45,787.50	45,787.50	45,787.50	-	Гэр анги шалны халаалттай болсон.	татах
17	Сандал	12	ш	25	4,273.50	106,837.50	106,837.50	-	Хүүхэд гэмтээх магадлалтай тул актлах	устгах
18	Тоглоомын тавиур	16	ш	1	77,246.10	77,246.10	77,246.10	-	Элэгдэл дууссан, булан эвдэрсэн, тогтохоо байсан.	устгах
Тавилга, эд хогшлын дүн				44		1,493,854.91	1,493,854.91	-		
Нийт дүн				50		2,910,839.81	2,910,839.81	-		
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө					789,657.11					
Татан төвлөрүүлэх хөрөнгө					2,121,182.70					
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/										